

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№22/561

ШУС, НУС

2021

**ХҮНИЙ ХУВИЙН НУУЦЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТЫН ОРЧИН ҮЕИЙН  
ХАНДЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Б.Баярмаа\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, магистр (МА)

**Түлхүүр үгс:** Хүний хувийн мэдээлэл, дангааршил, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эрх зүйн зохицуулалт, эрэн сурвалжлах сэтгүүл зүй, их өгөгдөл

**Х**үний хувийн нууцын тухай ойлголт нь сэтгүүлчийн мэдээлэл олох, боловсруулах, түгээх үйл ажиллагаатай холбоотой чухал ойлголт бөгөөд хүний эрх, сэтгүүлчийн ёс зүй, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эрх зүйн асуудлуудыг хөнддөг. Хүний хувийн нууцтай холбоотой судалгааг ихэвчлэн хууль, эрх зүйн салбарын хүрээнд хийж байна. Ингэхдээ ерөнхий байдлаар буюу халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хамаарах шинжид (хувийн мэдээлэл гэдэг утгаар бус бусад хүн дур мэдэн баривчлах, мөрдөн мөшгөхгүй байх гэдгээр) нь тулгуурлан дурдаж, тодорхойлж, судалж ирсэн. 2016 онд хүний хувийн нууцын тухай сэдвээр дагнасан анхны бакалаврын судалгааны ажил хийгдсэн бөгөөд үүнээс хойш Б.Цэвэлмаа 2017 онд, М.Хатанзориг 2021 онд сэдэвчилсэн судалгаа-

ны ажлууд нийтэлжээ. Мөн Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуультай холбоотойгоор Засгийн газар судалгаа хийж, 2021 онд Улсын Их Хуралд хуулийн төсөл өргөн бариад байна. Харин хүний хувийн мэдээллийг сэтгүүл зүйтэй холбон судалсан сэдэвчилсэн судалгааны ажил одоогоор байхгүй. Энэхүү ажил нь хүний хувийн нууцын тухай ойлголтын орчин үеийн хандлага, хүрээ, хязгаарыг тодруулах, түүнтэй холбоотой ойлголтуудын ялгааг гаргах, сэтгүүлч, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл холбогдсон хэргийг хэрхэн зохицуулж буйг илрүүлэх зорилготой.

Контент үйлдвэрлэлийн салбарын өсөлт, хэрэглэгчийн зан байдлын өөрчлөлт, технологийн хөгжил, их өгөгдлийн хуримтлал, цар тахлын үеийн нийгмийн нөхцөл байдал нь хувь хүний нууцын тухай ойлголтын хүрээг тэлсээр байна. Арилжааны байгууллагууд хэрэглэгчийн хурууны хээ, регистрийн дугаар зэрэг тухайн хүнийг тодорхойлох мэдээллийг цуглуулах мөн дуу-

дүрсний бичлэгийн төхөөрөмж ашиглан хувь хүний нууц, дангаарших орон зайд халдсан үйлдлүүд нэмэгдэж буйгаас эрх зүйн салбарт “хүний хувийн нууц” гэсэн ойлголтыг эргэн харах зайлшгүй шаардлагатай болжээ. Монгол Улсын хууль, эрх зүйн баримт бичигт хүний хувийн нууцад хамаараагүй атлаа ёс зүй, нийгмийн хэм хэмжээний үүднээс зайлшгүй багтах ёстой генетик, биометрик зэрэг шинэ төрлийн мэдээллүүдтэй сэтгүүлчид хэрхэн ажиллах нь тодорхойгүй байна. Мөн хувь хүнтэй холбоотой ямар мэдээллийг сэтгүүлч олон нийтэд ил болгох, ямар мэдээлэлд халдахгүй байх хүрээ, хязгаарыг шинээр тодорхойлох шаардлагатай боллоо.

Монгол Улсын Үндсэн хуульд хувь хүний дангаарших орон зайг баталгаажуулсан. Арван зургаадаугаар зүйлийн 13-г “халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан. Мөн 1995 онд баталсан Хувь хүний нууцын тухай хуульд “хувь хүний нууц” гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ

гэж тодорхойлсон. Ингээд хувийн нууцыг 1/захидал харилцааны, 2/эрүүл мэндийн, 3/хөрөнгийн, 4/гэр бүлийн, 5/хуулиар тогтоосон бусад нууц хэмээн ангилсан. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хуульд хувийн нууцыг дээрх таван ойлголтын хүрээнд багтааж үздэг. Хувийн нууцыг ингэж төрөлжүүлэх нь системтэй ойлгоход тустай ч ийнхүү явцууруулснаар нийгмийн шинэ үзэгдэл, харилцааг зохицуулах багтаамжгүй болоход хүргэж байна. Дээрх хуульд хурууны хээ, тухайн хүний генетикийн мэдээлэл, цахим “мөр”, хувийн орон зайд халдсан дуу-дүрсний бичлэг зэрэг чухал мэдээллийг цуглуулах, боловсруулах, түгээхтэй холбоотой харилцааг зохицуулаагүй. Сэтгүүлч орон сууц, байгууллагын дотоод камераар бичсэн дүрсийг ашиглаж болох эсэх, биометрик мэдээллийг нийтлэлдээ дурдан хэрэглэж болох эсэх, бэлгийн чиг хандлагыг нь тодорхойлсон мэдээллийг нийтийн ашиг сонирхлын үүднээс олон нийтэд дэлгэж болох эсэх нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиар зохицуулагдаагүй байна. Мөн “илт” хохирол учруулсан байх гэсэн өндөр шалгуур нь сэтгэл санаагаар хохирсон, ялгаварлан гадуурхагдсан хүний эрхийг энэ хуулийн хүрээнд хамгаалж чадахгүйд хүрэх эрсдэлтэй.

**Э**рх зүйн салбарт халдашгүй чөлөөтэй байх, хувь хүний нууц, хүний хувийн нууц, хүний хувийн мэдээлэл, хувь хүний эмзэг мэдээлэл, хүний халдашгүй байх эрх, хувь хүний дангааршил

зэрэг ойлголтуудыг ашигладаг. Хувь хүний нууц, хүний хувийн нууц нь right to privacy-тай дүйх ижил ойлголт. Гэхдээ “хүний хувийн нууц” нь хэл, найруулгын хувьд илүү тохиромжтой. “Хувийн” гэдэг үг нь “хүн”-ийг бус “нууц”-аа тодорхойлноор илүү нарийвчилсан ойлголт болж чадна. Нэг ойлголтыг хоёр янзаар илэрхийлэх нь тодорхойгүй, эргэлзээтэй байдал үүсгэх эрсдэлтэй тул нийтээр “хүний хувийн нууц” гэсэн нэршил ашиглахыг санал болгож байна. “Иргэний хувийн нууц гэдэгт тодорхой хувь хүн өөрийн нэр төр, алдар хүндэд харшилна гэж үзээд бусдад мэдэгдэхээс нууцалж явдаг бие эрхтний далд гажиг, согогоос эхлээд нэр төртэй холбоо бүхий ямар ч зүйл байж болно” (Г.Совд, 1999) гэж судлаач Г.Совд үзжээ. Бусад судлаачдын бүтээлд ч хувь хүн өөрөө хувийн нууцаа тодорхойлох бөгөөд, хувь хүний хүсэл, эрмэлзлээс шалтгаалдаг гэсэн өргөн утгаар нь авч үзсэн тайлбар түгээмэл байна.

Харин хүний эмзэг мэдээлэлд (sensitive information, sensitive data) нийтэд ил болгосноор хувь хүний амьдралд ноцтой хүндрэл учрах нэн эрсдэлтэй мэдээллийг багтаана. Хүний эмзэг мэдээлэлд юу багтах нь тухайн орны иргэдийн сэтгэлгээ, соёл, амьдралын хэв маяг, эрх зүйн орчноос хамаардаг.

**Х**үний халдашгүй байдал, халдашгүй байх эрх (security of person) нь өмнөх ойлголтуудаас өөрөөр, хууль бус мөрдлөг, баривчилгаанаас ангид байх гэсэн агуулгаар практикт ашиглагддаг.

Тодруулбал, хуулийн байгууллагаас иргэний хувийн орон зайд нэгжлэг хийх, мөрдөн байцаахтай холбоотой харилцааг багтаан ойлгодог. Халдашгүй чөлөөтэй байх гэдэг нь өөрийн жам ёсны шинж чанараас үүдэлтэй бөгөөд хуулиар баталгаажсан, хэн боловч хөндлөнгөөс дур мэдэн халдаж үл болох туйлын агаад салшгүй эрхийн цогцолбор (Хүний эрхийн Үндэсний Комисс, 2012) юм.

Тэгвэл хувь хүний дангааршил нь эрх зүйн салбарт хувь хүний нууцад юуг багтаахтай холбоотойгоор гарч ирсэн ойлголт бөгөөд англи хэлэнд “privacy” гэдэг үгтэй дүйнэ. Зарим судлаач хувь хүний нууц гэдэг нь Хувь хүний нууцын тухай хуульд заасан шиг “мэдээ, баримт бичиг, биет зүйл”-ээр хязгаарлагдахгүй учир илүү өргөн хүрээг хамруулахын тулд “дангааршил” гэсэн үг хэрэглэхийг санал болгожээ. Хэдийгээр privacy-д агуулгын хувьд хувийн орон зай, мэдээллийн халдашгүй байдлыг ойлгож байгаа боловч түүнийг тайлбарлах онол, хандлагаас шалтгаалаад тодорхой контекст дангаар байх эрх, шийдвэр гаргахдаа бусдын нөлөөнөөс ангид байх эрх зэрэг ялгаатай бөгөөд бие даасан утгуудыг илэрхийлдэг. Тэр тусмаа аюулгүй байдал, хүний эрхийн хүрээнд ач холбогдол нь улам өндөрсөн, нэр томъёоны хувьд цаашдаа салбар бүхэнд олонтоо хэрэглэгдэх ухагдахуун болж байгаа учраас (1) байнга олон үгээр (дор хаяж гурваас дээш үг ашиглаж) ярих буюу бичих, (2) хам утгаас шалтгаа-

лаад тохиолдол бүрд өөр өөр үгсээр (хувийн мэдээллийн халдашгүй байдал, хувийн орон зайн халдашгүй байдал, амины эрх, хувийн халдашгүй байх эрх гэх мэт) нэрлээд байж болохгүй (М.Хатанзориг, 2021) гэсэн шинэ хандлага байна.

АНУ-ын иргэн Чарлз Катзтай холбоотой хэрэг нь хувь хүний орон зай, хүний хувийн мэдээллийн хүрээ, хязгаарыг тодруулахад практикт сонирхолтой жишиг болдог. Нэхэмжлэгч Чарлз Катз нь телефон утсаар спортын бооцооны мэдээлэл дамжуулан холбооны хуулийг зөрчсөн хэрэгт холбогдсон. Засгийн газар нэхэмжлэгчийн утсаар ярьсан бүхээгийн гадна чагнах төхөөрөмж суурилуулан яриаг нь нотлох баримт болгожээ ([www.casebriefs.com](http://www.casebriefs.com)).

Гол маргаан нь нууцаар бичиж авсан утасны бүхээг дэх яриаг нь тухайн хүний эсрэг нотолгоо болгон ашиглаж болох эсэх талаар байв. Дээд шүүхийн шүүгч Жон Харлан АНУ-ын Үндсэн хуулийн дөрөвдүгээр нэмэлт өөрчлөлт нь газар, байршлыг биш хүнийг хамгаалдаг гэж үзсэн. Ингэхдээ нэгдүгээрт, тухайн хүн өөрийгөө хувийн орон зайд ганцаараа, халдашгүй байна гэж төсөөлсөн, хоёрдугаарт энэ нь хувийн орон зай, хүний хувийн нууц гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрөх ёстой гэж тайлбарлажээ. Үүгээр бол хүн утасны бүхээгт ороод хаалгаа хааж, төлбөрөө төлсөн бол өөрийн хувийн орон зайгаа үүсгэсэн гэж үзэх үндэстэй юм ([constitutioncenter.org](http://constitutioncenter.org)).

Шүүгч Жонн Харланы уг хэрэгт дэвшүүлсэн шалгуурыг Катзын сорил хэмээн нэрлэдэг. Катзын сорилын гол цөм нь “хувийн орон зайн үндэслэл бүхий төсөөлөл бөгөөд аливаа орон зайг дангаарших буюу бусдаас тусгаар орших боломжтой хэмээн бодсон хувь хүний хүлээлт юм. Учир нь сорилын философи үндэслэл нь “хуулиар тогтоосон дангаарших эрхийн хамгаалалт нь ямар нэгэн материаллаг эд хөрөнгө, газар бус тухайн эрхийг эдлэх хүнд тулгуурладаг” гэх тайлбар мөн. Өөрөөр хэлбэл, дангаарших эрхийн талаарх хуулийн үзэл баримтлал нь эд хөрөнгө, газрыг бус хүнийг хамгаалдаг гэсэн үг. Тиймээс хүн өөрөө тодорхой газрыг хувийн орон зай гэж бодсон, төсөөлсөн нь нийгмийн нийтлэг үнэлэмжээр зөвтгөгдвөл тухайн газар нь Үндсэн хуулийн хамгаалалтад хамаарна. Гэвч нөгөө талаар, энэ өнцгөөс дангаарших эрх хамгийн их хамаатай орон гэр ч бас зарим тохиолдолд хувийн орон зайд тооцогдохгүй байх боломжтой (М.Хатанзориг, 2021).

Дээрх жишээнээс харахад [zarig.mn](http://zarig.mn) сайтын сурвалжлагч өмгөөлөгч Б.Баасанцогтыг хоол идэж байхад нь гэнэт очин мэдээлэл өгөхийг шаардсан нь хувь хүний дангааршлын орон зайд халдсан жишээ байж болох юм. Энэ тохиолдолд Катзын сорилыг авч үзье. Хэдийгээр зоогийн газрын задгай талбайд хоол идэж байсан ч гэсэн нэгд, тухайн хүн өөрийгөө бусдаас тусдаа, хэвлэл мэдээллийнхнээс далд байна гэж төсөөлсөн. Хоёрт,

зоогийн газарт хоол идэж байхад нь гэнэт бичлэг хийх нь хүний эрхийг зөрчиж байна гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрч, тус сайтын сурвалжлагчийг шүүмжилсэн. Түүнчлэн, машиндаа суухад нь сэтгүүлч машины хаалгыг татаж, онгойлгохоор түрэмгийлж байгаа нь хувийн орон зайд халдсанд тооцогдох юм. Гэхдээ энд “зоогийн газар нь задгай, хаалтгүй байсан” гэх үндэслэлийг ярьж, сэтгүүлчийг зөвтгөх тал бас бий. Учир нь Катзын жишээг тайлбарлахдаа хэрэв хүн задгай тагтан дээр гарч ярьсан, хүн өөрөө бусдаас тусгаарлагдах оролдлого хийгээгүй эсвэл бусдыг урьсан тохиолдолд хувь хүний орон зайд халдсан, дангаарших эрх нь зөрчигдсөн гэж үзэхгүй хэмээн тайлбарласан байдаг. Хэрэв сэтгүүлч задгай талбайд хоол идэж байхад нь мэдээлэл авахаар очоогүй, шалгаагаагүй, зөвхөн дүрс, зураг авсан бол хувийн орон зайд халдсан болохгүй. Харин мэдээлэл авахаар түрэмгийлснээрээ бурууджээ гэх зэргээр үйл явдлыг Катзын сорилын дагуу задлан тайлбарлаж болох юм. (Катзын сорилын хоёр шалгуурыг хоёуланг нь хангасан тохиолдолд хүний хувийн орон зай, мэдээлэлд халдсан гэж үзнэ). Хэрэв олны танил хүн гэртээ зочид урьж баяр тэмдэглэж буй зургийг сэтгүүлч олон нийтэд дэлгэвэл энэ нь хувь хүний нууцад халдсан хэрэгт тооцогдохгүй гэсэн үг. Харин гэрийн эзэн гэртээ зочин урьсан ч гэсэн хэсэг хугацаанд өрөөнд орж, хөшгөө хаагаад хаалгаа цоожилж, өөрийгөө бусдаас тусгаарлах оролдлого

хийсэн байхад ямар нэг аргаар зураг, бичлэг хийх, өрөөнд дайран орох замаар мэдээлэл олж авах нь хувийн орон зай, хүний хувийн нууцад халдсан явдал болох юм. Сэтгүүлч, зураглаачид цагдаагийн алба хаагчидтай хамтран зочид буудлуудад “шөнийн сурвалжилга” нэрээр гэнэт нэвтрэн орж, бичлэг хийдэг нь Катзын сорилын хоёр шалгуурыг бүрэн дүүрэн хангана. Нэгд, тухайн хүн бусдаас нууц, далд байхын тулд төлбөр төлөн буудлын өрөөг захиалсан, хоёрт хэн дуртай нь буудлын өрөөнд нэвтэрч орох нь (гүйцэтгэх ажиллагаа л биш бол) хүний эрх зөрчсөн үйлдэл гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрнө.

**Е**вропын Парламент болон Европын Зөвлөлөөс 2016 оны дөрөвдүгээр сарын 27-нд гаргасан тогтоол (Regulation (EU) 2016/679 of the European Parliament and of the Council)-д хүний хувийн мэдээллийг тодорхойлохдоо тухайн хувь хүнийг шууд болон шууд бусаар таних, таньж болохуйц мэдээллийг хэлэх бөгөөд үүнд нэр, регистрийн дугаар, байршлын өгөгдөл мэдээлэл, онлайн орчинд танихуйц мэдээлэл болон бусад биеийн, сэтгэл зүйн, удамшлын, сэтгэцийн, эдийн засгийн, соёлын, нийгмийн мэдээллүүдийг багтаана гэж хүрээг нь тодорхойлсон нь хувь хүний эрхийн талаарх орчин үеийн хандлага, нийгмийн шаардлагыг тусгаж чаджээ. Мөн хүний хувийн эмзэг мэдээлэлд арьс, яс үндэс, улс төрийн үзэл бодол, шашин философийн итгэл үнэмшил, тухайн хүнийг таниулах генетик, биометрик мэдээ-

лэл, эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл, хүний бэлгийн амьдрал, бэлгийн чиг баримжааг хамруулсан байна.

Сэтгүүл зүйд хүний хувийн нууц, хүний эмзэг мэдээлэл, дангааршил зэрэг ойлголтын агуулгын ялгаа, хэрэглээг шинээр тодорхойлохгүйгээр ёс зүйтэй, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болсныг дараах жишээгээр тайлбарлаж болно. Сонгуулийн үеэр нэр дэвшигчдийг яс, үндсээр нь ялгаварлах явдал түгээмэл байна. 1993 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр нэр дэвшигч П.Очирбатыг хятад гаралтай гэх мэдээлэл тарж байсан бол 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр мөн нэр дэвшигч М.Энхболдыг хятад гаралтай гэсэн эх сурвалжийн мэдээллийг зарим цахим сайт дамжуулжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж, яс, үндсээр ялгаварласан хэрэг. Үүнээс гадна хүний хувийн нууц, хувь хүний эмзэг мэдээлэлд халдаж буй явдал. Сэтгүүлчид хятад гаралтай нь үнэн, худал эсэх талаар мэдээллийг тодруулах, тодруулахаар эх сурвалж хайх, энэ сэдвийг хөндсөн бусдын мэдээллийг дамжуулах нь өнөөгийн нийгмийн хэм хэмжээ, ёс суртахуунд нийцэхгүй. Мөн Grandnews.mn-д гарсан “Урлагийн улаан Христич нар” гарчигтай мэдээлэл (grandnews.mn) нь хүний хувийн эмзэг мэдээлэл болох шашны итгэл үнэмшлийг ил болгосон ёс зүйгүй үйлдэл болжээ. Хэрэв тухайн мэдээлэлд нэр нь дурдагдсан хүн уг мэдээллийг өнөөгийн нийгмийн хэм хэмжээний

дагуу хувийн мэдээллийг олон нийтэд ил болгосон гэж үзэж шүүхэд хандвал АНУ болон Европын холбооны улсад заргаа авах магадлалтай ч манай улсад боломжгүй. Учир нь Хувь хүний нууцын тухай хуульд шашны итгэл үнэмшлийг дурдаагүй.

Уг хуулийн үйлчлэлд багтаагүй ч хүний хувийн нууц гэдэг нь нийтээр хүлээн зөвшөөрөхүйц мэдээлэлтэй холбоотой тохиолдлыг шүүх хэрхэн шийдсэнийг авч үзье. Нэхэмжлэгч А нь хариуцагч Б-д холбогдуулан Facebook-т өөрийнх нь зурагтай, ажил төрөл, овог нэрийг ил тодорхой дурдан нөхөр В-тэйгээ нууц амрагийн холбоотой байсан хэмээн доромжилсон үгсээр олон түмний дунд цацаж эрх, эрх чөлөө, нэр төр, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэж үзэн нэр төр сэргээлгэж, сэтгэл санааны хохирол 30 сая төгрөгийг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан. Хариуцагч Б-нь Facebook-т бичсэн “...гэр бүлтэй хүнтэй дөрвөн жил гаруй явалдаж хэд хэд баригдаж янз янзын утасны дугаар сольж мессеж бичиж...” гэсэн мэдээлэл нь Хувийн нууцын тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй гэж үзээд шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

**Ш**үүх хэргийг шийдэхдээ дараах байдлаар дүгнэлт хийсэн байна. Нэгдүгээрт, хариуцагч тараасан “нэхэмжлэгч гэр бүл бүхий хүнтэй гэр бүлээс гадуурх харилцааг бий болгосон” гэсэн мэдээлэл нь бодит байдалд нийцсэн байх учир нэр төр гутаагдсан гэж үзэх үндэслэлгүй. Хоёрдугаарт,

дээрх мэдээлэл нь Хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хувийн нууцад хамаарахгүй учир нэхэмжлэгч нь түүнийг тараасантай холбоотойгоор учирсан гэм хороо арилгахыг шаардах эрхгүй (Б.Цэвэлмаа, 2017) гэсэн дүгнэлт хийжээ. Энэ нь хүний хувийн нууцын асуудлыг шүүх байгууллага өргөн утгаар тайлбарлан хэрэглэхгүй, өмнө дурдсан таван ангиллын хүрээнд л авч үзэж байгааг харуулна.

Хувийн нууцын хүрээг шинээр тодорхойлох цаг үе, нийгмийн хэрэгцээг харгалзан үзэж УИХ-д Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг өргөн бариад байна. Уг хуулийн төсөл нь дээр дурдсан Европын Парламент болон Европын Зөвлөлөөс 2016 оны дөрөвдүгээр сарын 27-нд гаргасан тогтоолын агуулгыг хүлээн зөвшөөрч, тусгажээ. Тус хуулийн төсөлд одоо мөрдөж буй Хувь хүний нууцын тухай хуульд тодорхойгүй заасан, дурдаагүй ойлголтуудыг багтаасан. Тухайлбал, -“Хүний хувийн мэдээлэл” гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг, эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг,

-“Хүний эмзэг мэдээлэл” гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, хөрөнгө, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, цахим гарын

үсэг, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн чиг хандлага, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг,

-“Генетик мэдээлэл” гэж биологийн сорьцын шинжилгээгээр тогтоосон хүний бие махбод, эрүүл мэнд, өвлөн авсан удамшлын шинж чанарыг илэрхийлсэн дахин давтагдашгүй мэдээллийг,

-“Биометрик мэдээлэл” гэж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар хүнийг тодорхойлох боломжтой гарын хурууны хээ, нүдний солонгон бүрхэвч, нүүр царай, дуу хоолой, биеийн хөдөлгөөний онцлог шинж зэрэг хүний бие махбодтой холбоотой хүний биеийн давхцалгүй өгөгдлийг” гэх зэргээр шинэ ойлголтуудыг оруулснаараа давуу болжээ.

**Т**ус хуулийн төслийн гурван заалт бүхий 12 дугаар зүйлд сэтгүүл зүйн зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой зохицуулалт тусгасан. Сэтгүүл зүйн зорилгоор (1) мэдээллийн эзний зөвшөөрлөөр, эсхүл (2) нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж болно гэжээ. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд “Монгол Улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учруулахгүйн үүднээс зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдолд төрийн холбогдох эрх бүхий байгууллага /албан тушаалтан/-ын

шийдвэрээр хувь хүний эрүүл мэндийн болон бусад нууцыг хуульд заасан хүрээнд ил болгож болно” гэж зөвхөн төрийн зарим байгууллага, албан тушаалтныг цохон онцолсон. Харин нийтийн эрх ашгийн үүднээс гэж үзвэл эрэн сурвалжилсан сэтгүүл зүйн бүтээлд хүний хувийн ямар ч мэдээллийг ил болгох боломжийг уг хуулийн төсөлд тусгажээ. Үүгээрээ сэтгүүлч хүний хувийн мэдээллийн аль хэсэгт халдаж болох, болохгүй заагийг тодорхой тусгасан, сэтгүүлчид нийтийн ашиг сонирхлын үүднээс ажилладаг онцлогийг харгалзан үзсэнээрээ давуу юм. “Хувь хүний нууц”-д юуг багтаах нь ойлгомжгүй байснаар сэтгүүлчид эрэн сурвалжлах нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэхдээ хүний хувийн мэдээлэл гэж нийтээр үздэг, төсөөлдөг бүх мэдээллийг ил болгохоос зайлсхийдэг байсан. Эсвэл эсрэгээрээ хуульд заагаагүй бусад шинэ төрлийн мэдээллийг хувийн нууц гэж үзэхгүйгээр нийгмийн хэм хэмжээг зөрчих тохиолдолд гардаг. Хэрэв сэтгүүлч шүүхийн өмнө “нийтийн ашиг сонирхлын үүднээс ил болгосон” гэдгээ нотолж чадна гэж үзвэл хуулийн барьергүй-

гээр мэдээллийг эрэн сурвалжлах, олон нийтэд дэлгэх боломжтой болох юм. Сэтгүүлч ямар ч тохиолдолд хөндөж болохгүй мэдээллийг нарийвчлан заахгүй, хүрээ хязгаар тогтоохгүй байх нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжил, цаашлаад хэвлэлийн эрх чөлөө, ардчиллыг бүрэн утгаар хэрэгжүүлэхэд нэн чухал билээ. Баримт, нотолгоог хуулийн байгууллага олж аваагүй, хуулийн дагуу авах боломжгүй бол сэтгүүлч “бусад” аргаар олж авч болохыг Сэтгүүлчийн ёс зүйн зарчимд тусгасан, олон улсад ч ийм жишиг хэрэгждэг.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлд дуу-дүрсний бичлэг хийх талаар зохицуулсан нь сэтгүүлч, олон нийтийн санал хуваагдан талцдаг

зарим асуудлыг нэг тийш шийдэх бололцоог нээхээр байна. Тухайлбал, орон сууцны эргэн тойрон, үйлчилгээний байгууллагын доторх дүрсийг бичиж, түүнийгээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж болох эсэх нь маргаантай байдаг. Камерыг зөвхөн оршин суугчдын аюулгүй байдлыг хангах, ажлын байранд эд хөрөнгийг хамгаалах,

«

**Хэрэв сэтгүүлч шүүхийн өмнө “нийтийн ашиг сонирхлын үүднээс ил болгосон” гэдгээ нотолж чадна гэж үзвэл хуулийн барьергүйгээр мэдээллийг эрэн сурвалжлах, олон нийтэд дэлгэх боломжтой болох юм. Сэтгүүлч ямар ч тохиолдолд хөндөж болохгүй мэдээллийг нарийвчлан заахгүй, хүрээ хязгаар тогтоохгүй байх нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжил, цаашлаад хэвлэлийн эрх чөлөө, ардчиллыг бүрэн утгаар хэрэгжүүлэхэд нэн чухал билээ.**

»



замын хөдөлгөөний мэдээлэл цуглуулах зорилгоор нүдэнд ил харагдахаар байршуулж болно. Харин хуульд өөрөөр заагаагүй бол ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, нийтийн үйлчилгээний газрын тусгай зориулалтын өрөө, караоке, зочид буудлын өрөө, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хэвтүүлэн эмчлэх өрөө зэрэг хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулахыг хориглоно. Мөн орон сууцанд өрхийн орох, гарах хэсгийг хамруулан дүрс бичих, орон сууцны дүрс бичлэгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээж болохгүй. Дүрс бичлэгийг мэдээллийн эзний зөвшөөрлөөр авсан байлаа гэхэд өөр бусад хүн багтсан тохиолдолд дүрс бичлэгийг тухайн хүнд харуулах, хуулбарлаж өгөхөөр тусгасан байна.

**Д**ээрхээс харвал Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл батлагдвал сэтгүүл зүйн салбарт хүний хувийн нууцтай холбоотой тодорхойгүй байсан олон харилцааг зохицуулахаар байна. Гэхдээ “хүний хувийн нууц” гэсэн ойлголт нь “мэдээ, баримт бичиг, биет зүйл” зэрэг объектив зүйлээр хязгаарлагдахгүй, харин хүн өөрөө хувийн нууц гэж үзэж, хамгаалах үйлдэл хийсэн эсэхийг харгалзан үздэг хандлагыг тусгаагүй.

Одоогоор хувийн нууцтай холбоотой нэхэмжлэлийг Иргэний хуулийн “Эдийн бус гэм хорыг арилгах”

511 дүгээр зүйл, Эрүүгийн хуулийн “Хувь хүний нууцыг задруулах” 13.11 дүгээр зүйлийн дагуу гаргаж байна. Ингэхдээ илүү иргэний эрх зүйн чиглэлээр хариуцлага ногдуулж байгаа нь судалгаа, шүүхийн практикаас ажиглагдлаа. Иргэд хувийн амьдрал, эрүүл мэндийн мэдээллийг нийтэд дэлгэвэл түүнийг хувийн нууцад халдсан гэхээс илүү нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж үзэн Иргэний хуулийн дагуу нэхэмжлэл гаргасаар байна. Жишээлбэл, “Тэргүүн” сонины 2007 оны 10 дугаар сарын дугаарт “Мөөөө аварга гэрийн хорионд байна” гэсэн материалд дархан аварга Ж.Мөнхбатын эрүүл мэндийн байдал ноцтой, гэртээ байгаа тухай бичжээ. Дархан аварга Ж.Мөнхбат эрүүл мэндийн хувийн нууцад халдсан гэж үзээгүй, харин нэр төр гутаасан хэмээн найман сая төгрөг нэхэмжилсэн. Чингэлтэй дүүргийн шүүх Иргэний хуулийн 21.2, 497, 511.1, 57.1 зэрэг заалтуудыг үндэслэн нэр төрийг нь сэргээн сониныг таван сая төгрөгөөр торгожээ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллээс үзвэл Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн дагуу 2020 онд 106 хэрэг шүүхээр шийдвэрлэгджээ. Гэхдээ үүнээс сэтгүүлч хариуцагчаар оролцсон хэргийг ялгаж бүртгэдэггүй учир сэтгүүлчид хувь хүний нууцад халдсанаар шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоон мэдээлэл байхгүй.




График 1. Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн дагуу шүүхээр хэлэлцэн шийдвэрлэсэн хэргийн тоо.

Харин Эрүүгийн хэргийн 13.11 дүгээр зүйлд “Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан бол...”, “Албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан бол...” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. 2020 онд албан үүргээ гүйцэтгэх явцдаа хүний хувийн нууцыг задруулсантай холбоотой 10 хэрэг хянан шийдвэрлэгдсэн. Үүнд сэтгүүлч хариуцагчаар оролцсон эсэхийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ялгаж бүртгээгүй байна. Мөн шүүхийн шийдвэрийн цахим сан shuukh.mn-д 2020 оноос хойш сэтгүүлч дээрх заалттай холбоотойгоор хариуцагчаар оролцсон хэргийг шүүх шийдвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй.

**А**влигын эсрэг хуульд хувь хүний нууц мэдээлэлтэй хэрхэн ажиллах талаар заалт бий. Хуулийн 8.2-т зааснаар “нийтийн албан хаагч албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй бөгөөд ийнхүү мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгуул-

лага, хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй” гэж заасан. Тодруулбал, авлигыг илчлэх явцдаа хүний нууц мэдээллийг ил болгосон бол нийтийн албан хаагч хуулийн хариуцлага хүлээхгүй, харин бусад этгээд буюу иргэн, сэтгүүлчид, хүний эрх хамгаалагчид хуулийн хариуцлага хүлээхээр зохицуулагдсан байна.

Хүний хувийн нууцын орчин үеийн хандлагыг эрх зүйн зохицуулалтад тусгах, хууль боловсруулагчид, сэтгүүлчид, иргэд нэг ойлголтой байх шаардлагатай болжээ. 1995 онд баталсан “Хувь хүний нууцын тухай хууль” нь сэтгүүлчийн хүний хувийн нууцтай ажиллах хязгаар, шаардлагыг тодорхойлон зохицуулж чадахгүй, практикт хэрэглэхдээ хэт явцууруулснаар шүүх байгууллага өнөөгийн нийгмийн хэм хэмжээнд нийцсэн шийдвэр гаргаж чадахгүй байна. Иргэд сэтгүүлчийг хүний хувийн нууцыг ил болгосон гэж үзвэл Иргэний хуулийн дагуу нэхэмжлэл гаргах нь түгээмэл ч шүүхийн байгууллага сэтгүүлчийн холбогдсон хэргийг тусад нь бүртгэхгүй байгаагаас тоон мэдээ-

лэл алга. Хүний хувийн нууц, хүний хувийн мэдээлэл, хувь хүний эмзэг мэдээлэл, хүний халдашгүй байх эрх, хувь хүний дангааршил зэрэг ойлголтууд нь хоорондоо ялгаатай утга илэрхийлнэ. Мөн “хувь хүний нууц”, “хүний хувийн нууц” нь right to privacy-тай дүйх ижил ойлголт ч гэсэн хэл, найруулгын хувьд “хүний хувийн нууц” гэсэн нэршил ашиглахыг санал болгож байна. Монгол Улсын хууль, эрх зүйн хүрээнд сэтгүүлч хүний хувийн мэдээлэлтэй хэрхэн ажиллах нь тодорхойгүй байгаа бөгөөд сэтгүүлчийн нийтийн эрх ашгийн төлөө эрэн сурвалжилдаг ажлын онцлогийг харгалзан үзсэн зохицуулалт одоогоор байхгүй, хуулийн төсөлд тусган хэлэлцэж буй. Хүний хувийн нууц нь тухайн хүний нууцлах хүсэл, сонирхлын түвшин хүртэл хамаарах учир сэтгүүлчид тохиолдол бүрд Катзын сорилыг авч үзэн, хүний хувийн мэдээлэлд халдаж буй эсэхээ үнэлж, дүгнэх бололцоотой. Улсын Их Хуралд өргөн барьсан “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл” нь хүний хувийн нууцтай холбоотой орчин үеийн хандлагыг тусгасан ч энэ ойлголт нь объектив зүйлээр хязгаарлагдахгүй, тухайн орны ард иргэд, тухайн хүн өөрөө нууц гэж үзэж, хамгаалах үйлдэл хийсэн эсэхийг харгалзан үздэг хандлагыг тусгаагүй. Эдгээрээс үзвэл, их өгөгдлийн хуримтлал, технологийн дэвшил, сэтгүүл зүйн үйл ажиллагаатай холбоотой нийгмийн шинэ харилцааг зохицуулах үүднээс хүний хувийн нууцтай

холбоотой эрх зүйн шинэчлэл нэн шаардлагатай болжээ.

### Эшлэл

1. Совд Г. 1999. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх. Харьцуулсан эрх зүй. УБ. х.70.
2. Хатанзориг.М. 2021. “Хувь хүний дангаарших эрхийн талаарх Америкийн нэгдсэн улсын дээд шүүхийн голлох шийдвэр, түүний зарим үр дагавар №1: Катзын маргаан. ЭШӨ. legaldata.mn. УБ. х.8.
3. Хүний эрхийн Үндэсний Комисс. 2012. Хүний эрхийн товч тайлбар. УБ. х.26.
4. Цэвэлмаа.Б. 2017. “Хувийн амьдрал халдашгүй байх эрхийн иргэний хууль дахь хамгаалалтыг Үндсэн хуулийн эрх зүйн талаас авч үзэх нь. ЭШӨ. legaldata.mn. УБ. х.5.
5. <https://www.casebriefs.com/blog/law/criminal-procedure/criminal-procedure-keyed-to-israel/arrest-search-and-seizure/katz-v-united-states-2/>
6. <https://constitutioncenter.org/blog/katz-v-united-states-the-fourth-amendment-adapts-to-new-technology/>

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Совд Г. 1999. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх. Харьцуулсан эрх зүй. УБ.
2. Хатанзориг. М. 2021. Хувийн мэдээллийн ашиглалт, хамгаалалт үндэсний аюулгүй байдлын уламжлалт бус сорилт болох нь: эрх зүйн шинэчлэлээр шийдвэрлэх арга зам. ЭШӨ. legaldata.mn. УБ.
3. Хатанзориг. М. 2021. “Хувь хүний дангаарших эрхийн талаарх Америкийн нэгдсэн улсын дээд шүүхийн голлох шийдвэр, түүний зарим үр дагавар №1: Катзын маргаан. ЭШӨ. legaldata.mn. УБ.

4. Цэвэлмаа.Б. 2017. “Хувийн амьдрал халдашгүй байх эрхийн иргэний хууль дахь хамгаалалтыг Үндсэн хуулийн эрх зүйн талаас авч үзэх нь. ЭШӨ. legaldata.mn. УБ.
5. Авлигын эсрэг хууль. 2006. УБ.
6. Европын Парламент болон Европын Зөвлөлөөс 2016/4/ 27-ны тогтоол
7. Хувь хүний нууцын тухай хууль. 1995. УБ.
8. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл. 2021. УБ.
9. Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан бичиг. 2021. УБ.
10. [www.casebriefs.com](http://www.casebriefs.com)
11. [www.constitutioncenter.org](http://www.constitutioncenter.org)
12. [www.grandnews.mn](http://www.grandnews.mn)
13. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
14. [www.legaldata.mn](http://www.legaldata.mn)
15. [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)

### Summary

It is becoming difficult to conduct professional journalism without re-describing the misunderstanding and

usage in area of the privacy, security of privacy and personal sensitive data of journalism.

Five categories of security of privacy and narrow practical usage on the right to privacy law amended 1995 are forming the uncertainty in the investigating journalism. In this article, the description and recommendation on modern tendency in which journalists consider the limit of personal information. The crime and dispute related with the security of privacy in which journalist and mass media involved can be resolved provisions of Mongolian Civil law and Criminal law. However, in case of personal life and health information is published on media, individuals consider it is related with personal dignity and create the claim on Civil law. The legal modernization related with the security of privacy is needed to regulate the new social relationship in relation with big data and technology advancement and clear the investigating journalism activities.